



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар A/5

Мөрөн сум

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.2, 22 дугаар зүйлийн 22.4.2, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 32 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн 2022 оны 1 дүгээр хуралдаанаар хэлэлцэсний дагуу “Нутгийн аваргууд” сургуулийн 2 давхар хуучин байрыг Залуучуудын хөгжлийн төв болгох төлөвлөлт, үйлчилгээний зураглал гаргах ажлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

Б.Мөнгөн-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн)

Ажлын хэсгийн гишүүд:

Ц.Гончиг- (Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэд дарга, салбар зөвлөлийн гишүүн)

Д.Батцоож- (Аймгийн Стандарчлал, хэмжил зүйн хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн)

Д.Идэрмөнх- (Мөрөн сумын Засаг даргын орлогч, салбар зөвлөлийн гишүүн)

С.Отгонжаргал-(Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн гэр бүл, хүүхэд, залуучууд, жендэрийн бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн)

Э.Эрдэнэцэцэг- (Салбар зөвлөлийн гишүүн)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Ч.Дашбаяр (Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, салбар зөвлөлийн нарийн бичиг)

2. Залуучуудын хөгжлийн төвийн ажил, үйлчилгээ, орчин, нөхцөлийн талаарх шаардлагатай тооцоо, судалгаа, төлөвлөлтийг хийж, түүнд бусад аймаг, дүүргийн арга, туршлага, залуучууд, залуучуудын төрийн бус байгууллагуудын санал, санаачилгыг тусгаж, 2022 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн дотор нэгтгэн танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН